

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дашдаваа	Дугаар	L272
Оршин суугаа аймаг	Төв аймаг	Оршин суугаа сум	Сэргэлэн сум
Төрсөн газар	Сэргэлэн сум	Төрсөн он	1934
Ажил мэргэжил	Өндөрнастан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Баргын хурал, Бамбар эрдэнэ ламын хийд	Сүм хийдийн дугаар	ТӨСЭ 064, ТӨСЭ 065
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны11-р сарын 3	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат

Төв аймгийн Сэргэлэн сумын Баргын хурал, Бамбар эрдэнэ ламын хийд

Мөнхбат: Тэгэхээр Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг, Сэргэлэн сумын тавдугаар багийн нутагт байдаг Нарийны хөтөл хэмээх газар байдаг нийслэлчүүдийн шүтээн Ээж хад хэмээх газрын зүүхэнтээ нутаглаж байгаа Дашдаваа гэдэг энэ нас сүүдэр 73-ны насыг зооглож яваа энэ эрхэм бууралтай бид нар дараах ярилцлагыг хисэн юм аа. Тэгэхээр манай ярилцагын гол зорилго Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт 1937 оноос өмнө байсан бурхан шашны томоохон төв Баргын хурал, Бамбар Эрдэнэ ламын хийд гэсэн энэ хоёр буддын шашны томоохон төв хийдүүдийн тухай түүхэн сурвалж авахаар Дашдаваа гүайтай дараах ярилцлагыг хийлээ.Тэгэхээр таниас дараах хэдэн зүйлийг асууя. Тэгэхээр энэ Сэргэлэн сумын нутагт байсан эхлээд энэ Баргын хурлын тухай ярилцагаа эхлээ. Баргын хурал маань хэдий үед байгулагдсан юм бол, хичнээн ламтай байсан юм бол, ямар ямар сүм дацангуудтай байсан юм бол энэ талаар таны мэдэж, сонсож цуглуулсан баримтанд ямархуу мэдээлэл байна, энэ талаар яриагаа эхлээ?

Дашдаваа: Тэгэхээр энэ манай хийд бол Төв аймгийн Сэргэлэн сумын зуун цагаан тэмээт гэдэг газар байдаг. За одоогийн Баргын хийдийн байсан газар нь цагаан чулуут гэдэг газар байдаг юм аа.Цагаан чулуутын орой дээр ганцхан гэр дугантай. Дуганы хувьд бол оройгүй, оройгүй дуган.Чухам яг хэдэн онд гэдгийг мэдэхгүй, баргууд орж ирээд л анх Богдод бараалхаад богдод нутаг гуйсан.Энэ нутаг орон байсан учраас бид нар хийдгүй байж болохгүй нь ээ. Өөрсдөө таалагдсан хийдээ барь гэсэн учраас анхны хийд одоо Тэр Дамчаачойлин гэж хийд барьж хурж байсан. 200 гаруй ламтай байсан. Хамгийн сүүл лам нь одоо 2005 онд бурхан боллоо. Маанийн Магсар гэж хүн байгаад, тэгээд одоо товчдоо л ийм дээ. Энэ хийдийг сайн мэдэх, түүхийг нь мэдэх хүн бол одоо уг нь надад түүх нь байна. Яг өндөөр миний гар дээр алга байна.Та нарт гаргаад үзүүлж чадахгүй байна. Юмыг нь болвол одоо энэ таван тэмээ ачсан гэж ярьдаг юм. Энийг Хөндлөн гэдэг газар нуусан гэдэг юм.Тэрийг нь бол одоо мэддэг хүн болд Идэш гэж хүн байдаг . Эмэгтэй хүн бий, тэр хүн бол зааж өгдөггүй юм байна лээ.Тэгээд сүүлийн үед бол энэ хийдийнхээ сууринд Баргын хийдийнхээ шороог авч ирээд оруулчихсан байгаа юм

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

аа.Тэгээд үндсэндээ одоо энэ Дашпэлжээлин хийд маань хоёр хийдйн тоосго шороо орсон, хоёр хийдийн суурь босчихсон явж байгаа учраас энийг тойроод 108 суварга барих шаардлагатай байгаа учраас ингээд эхлээд суварга бариад явж байна. Тэгэд ахицтай байгаа.

Мөнхбат: Тэгэхээр Баргын хийд маань ямар ч гэсэн Баргын хийд гэсэн нэр томъёоноос аваад үзэхээр 20-р зууны эхээр монгол орны зүүн хязгаараас одоо Халхын төв газар нутаг руу нүүж орж ирсэн Баргачуудын үүсэлтэй одоо холбоотой гэдэг нь бол мэдэгдэж байна, тийм ээ?

Дашдаваа: Энэ болвол ийм юм аа. Түвдэнванчиг гэж лам бий, Баргын хийдтэй хамт орж ирсэн.За энүүнийг сайн мэдэх хүн бод энэ Ринчендорж гэж Авдарбээр сумын анхны дарга байсан Бор гэж нэрлэгдэж явдаг тэр хоёр хүн маань энэ хоёр хүн бол тээр хийдийн хамгийн сүүлийн суурийг хаасан. Түвдэн гуай бол ерөөсөө лам хүн, ганц бие байж байгаад нас барсан. Ринчендорж гуай бол сумын дарга байж байгаад нас барсан. Энэ Сүхбаатар аймаг руу л хүүхдүүд нь байдаг юм шиг байгаа юм.

Мөнхбат: Тэгэхээр энэ Баргын хурал маань байнгын хурал байсан юм болов уу, цагийн хурал байсан юм болов уу, жас гэдэг юм уу, бурхан шүтээн нь юу байсан юм бол энэ талаар таны сонсож үзэж дуулсан юм юу байна?

Дашдаваа: Бурхан Лхам сахиустай байсан юм, гол сахиус нь. Энэ Дамдиндорж гэж манайд тахиад байгаа тэрний цагаан ямаатай Дамжаа. гэдгийг тахиж байсан юм байна лээ. За яахав хурал нь өдөр болгон хуралтай. Жаахан улсууд нь тэндээ байрлаад, голцуу барга улсууд байсан. Халх улсууд байгаагүй.Сүүлдээ Дандар Эрдэнэ ламынхаа хийд рүү нэлээн шилжиж орсон. Чухам яагаад орсон юм, тэр тийм харилцаа байсан юм шиг байна лээ.

Мөнхбат:Тэгэхээр тэр бурхны шашны лам нарын эсрэг авч эхэлсэн тэр буруу арга хэмжээ буюу 1937, 1938 оны үед энэ хүрээ хийдийн тэр Баргын хурлын ганц сүмийг тухайн үед нь нураагаад дуусгасан байдаг юм болов уу, хожим нь дөч, тавиад оны нүүрийг үзсэн байдаг юм болов уу, та энэ талаар үзэж сонсож дуулсан юм юу байдаг юм бол?

Дашдаваа. Яг тэр Баргын лам нарыг барихад нь нураагаад дуусгачихсан юм гэнэ лээ. Ерөөсөө нураагаад буулгаа байх ч юмгүй, гороо мороо ч үгүй. Чулуун ханатай гэр дуган, тойроод чулуун ханатай. Яг манай энэ урд ээжийн гэр шиг.

### **Бамбар Эрдэнэ ламын хийд**

Мөнхбат: Энэ Сэргэлэн сумын урд биеэр байсан Бамбар Эрдэнэ ламын хийд гэж ямархуу том хүрээ байсан юм, тэр Бамбар Эрдэнэ лам гэж бодит бие хүн байсан юм уу, энэний эхлээд нэр гарал үүслийн талаар ярилцлагаа эхэлвэл яасан юм бэ? Энэ дээр таны таамаг, одоо мэдэж байгаа зүйл юу байна вэ?

Дашдаваа. За Бамбар Эрдэнэ ламын хийд маань богдын сахиусыг тахиж байсан байгаа юм аа. Дамжаан дорлиг гэж, Дамжаан гэдэг маань улаан ямаа хөлөглөсөн сахиустай. Том хийд ээ. Манай энэ хийдийг толгойлж байсан Бамбар эрдэнэ лам гэдэг бол бодит хүн. Энэ өөрөөр хэлбэл зүүн талаасаа Боржигон аймгаас тодорч ирж байсан гэгээнтэн.Гурван настай хаан ширээнд , богдын хүрээнд сууж байгаад тэгээд насны эрхээр бурхан болсон.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дараагийн залуу дүр Бамбар Эрдэнэ лам гэдэг бол мөн 3 настайдаа тодорч, 25 настайдаа баригдаж таалал болсон гэдэг ийм түүх байдаг.

Мөнхбат: Тэгэхээр Бамбар Эрдэнэ ламын энэ туурь маань Төв аймгийн Сэргэлэн сумын төвөөс ямар зайд ямар нэртэй газар байдаг юм, одоо түүрийн байдал ямар байгаа юм энэ талаар ярилцагаа үргэлжүүлэе?

Дашдаваа: За тэгэхээр энэ Бамбар Эрдэнэ ламын хийд маань одоо түүрин дээр нь очихоор зөвхөн түүрийн шороонууд нь бий. За энэ хийдийг анх одоо баригдаад явснаас нь хойш одоо татаж буулгаад сургууль бариад сумын төв рүүгээ зөөгөөд ингээд үстчихсэн хйд байгаа юм. Үндсэндээ тэнд бол одоо зүгээр шороон довжоонууд үлдсэн юм аа. Би тэрийг одоо бас очиж үзэж энд дуган дотроо авчирч хийж байсан. За яахав лам нар бол нэлээн байсан. Одоо амьд сэрүүн үлдсэн лам гэвэл Баян суманд Дорж, Нацагдорж гэж өвгөн лам байж байгаа. Энэ сүүлийн дүр Бамбар Эрдэнэ багштайгаа хоёулаа тоглож наадаж нэг үеийн улсууд. Мөн Хэнгэрэг гэдэг лам амьд сэрүүн явж байна. Тэр хамгийн сүүлд гэсгүй болоод, цогчин дуганы гэсгүй байж байгаад одоо больсон хүн байгаа юм. За тэр Жамбалдорж гэж лам байна. Тэр хүрээ хийдэд сууж байсан лам амьд сэрүүн явж байна. Одоогоор ийм 3 лам амьд сэрүүн байна даа.

Мөнхбат: Тэгэхээр тухайн цаг үедээ Бамбар Эрдэнэ ламын хүрээ маань хичнээн ямар ямар дуган дацантай байсан юм бол, гол уншлага ном нв юу байсан юм бол, за жас сангийн хувьд орчин үеийн хэллэгээр бол санхүүгийн чадамж, чадавхи нь ямар байсан юм бол энэ талаар таны сонсож мэдсэн зүйл юу байна вэ?

Дашдаваа: Өө их том хүрээ байсан, Чадалтай хүрээ байсан, энэ нутагтаа бол. Энэ Шавийн аймгийн үүрийн 7 хутагтын нэг хутагт аа. Энэ Бамбар лам Үүрийн 7 хутагтын нэг хутагт нь байгаа юм. Богдоос хайрласан хутагтай, тамгатай хувилгаан хүн байгаа юм, түрүүчийн өвгөн багш дүр нь. Сүүлийн залуу дүр нь за яахав залуу байсан, бас л чадалтай сайн лам байсан гэж манай лам нар ярьдаг. Багш ингэж байсан, багш тэгж байсан гээд олон түүх байдаг. Ийм л том хийд байсан болохоор би заавал энэнийг хөл дээр нь, болдогсон бол хуучин байсан юмнуудыг бүгдийг нь одоо бариад бүтээчихмээр санагддаг юм, чадахгүй юм одоо. Гол хэдэн сахиус нь бол арван хангал хурж байсан, дамдин сахиустай байсан. За одоо мөнхийн хоёр юм модон дор байнгын бамбар гэрэл асч байх нь энэ нь бол одоо Богдод мэдээтэй хүрээ байсан.

Мөнхбат: Тэгэхээр одоо 1937, 1938 оны тэр бусармаг жилүүдийн дараахан мэдээж одоо тэр хүрээний том том лам нар цаг бусаар хэлмэгдээд явсан нь ойлгомжтой. Эндээс одоо хичнээн лам нар хэлмэгдээд явсан байдаг юм бол, хэд нь эргэж ирсэн байдаг юм бол энэ талаар одоо танд судалж сонсож мэдсэн юм байна уу?

Дашдаваа: За баригдаад явсан лам нар бол эргэж ирээгүй, тухайн үеийнхээ том лам нар нь. Зүгээр тэрнээс яахав тэр үедээ бол цорж лам байсан хүн нь бол эргэж ирж байгаад нас барсан, бурхан болсон байгаа. Үгүй яахав ер нь бол ихэнх нь баригдаад явчихсан юм байна лээ. Эргэж ирсэн нь бол...